| 210808      | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж   | 200,000.00            | 231,000.00             |
| 210809      | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх   | 488,650.00            | 1,589,500.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | <b>2,874,500.00</b>   | <b>1,150,000.00</b>    |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 2,874,500.00          | 1,150,000.00           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>6,697,323.19</b>   | <b>61,116,017.68</b>   |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>2,310,000.00</b>   | <b>49,843,000.00</b>   |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 2,310,000.00          | 49,843,000.00          |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>   | <b>3,332,123.19</b>   | <b>-</b>               |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 3,332,123.19          | -                      |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>                                | <b>-</b>              | <b>1,273,017.68</b>    |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | -                     | 1,273,017.68           |
| 213503      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 55,200.00             | -                      |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>  | <b>4,510,000.00</b>   | <b>28,402,966.27</b>   |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>   | <b>4,510,000.00</b>   | <b>20,890,000.00</b>   |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>4,510,000.00</b>   | <b>20,890,000.00</b>   |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | <b>4,510,000.00</b>   | <b>20,890,000.00</b>   |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал   | 4,510,000.00          | 20,890,000.00          |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>                                 | <b>(4,510,000.00)</b> | <b>(20,890,000.00)</b> |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>   | <b>-</b>              | <b>7,512,966.27</b>    |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  | <b>-</b>              | <b>-</b>               |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>   | <b>-</b>              | <b>7,512,966.27</b>    |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны           |                |
|-----------------------|--|-----------------------|----------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл             |                       |                |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                     | 663,695,200.00        | 634,832,402.14 |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 663,695,200.00        | 634,832,402.14 |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                       | 649,695,200.00        | 625,589,402.14 |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                     | 455,296,000.00        | 440,315,044.00 |
| 210101                | Үндсэн цалин   | 270,296,000.00        | 262,769,726.00 |
| 210102                | Нэмэгдэл   | 110,000,000.00        | 105,727,416.00 |
| 210103                | Унаа жоолны хөнгөлөлт  | 8,700,000.00          | 6,758,000.00   |
| 210104                | Урамшуулал   | 43,900,000.00         | 43,881,545.00  |
| 210105                | Гэрээт ажлын хөлс  | 22,400,000.00         | 21,178,357.00  |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>        | 61,465,000.00         | 57,962,234.74  |
| 210201                | Тэтгэврийн даатгал   | 43,253,100.00         | 40,528,223.26  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал   | 4,553,000.00          | 4,355,223.50   |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал  | 3,642,400.00          | 3,790,178.72   |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал   | 910,600.00            | 844,419.10     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал  | 9,105,900.00          | 8,444,190.16   |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>             | 16,912,000.00         | 15,644,282.32  |
| 210301                | Гэрэл, цахилгаан   | 3,400,000.00          | 2,253,782.32   |
| 210302                | Түлш, халаалт  | 13,440,000.00         | 13,330,500.00  |
| 210303                | Цэвэр, бохир ус  | 72,000.00             | 60,000.00      |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                      | 30,971,200.00         | 30,695,620.00  |
| 210401                | Бичиг хэрэг  | 2,533,200.00          | 2,512,400.00   |
| 210402                | Тээвэр, шатахуун   | 18,018,000.00         | 17,966,940.00  |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                           | 920,000.00            | 859,000.00     |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, жортон мэрэгчдийн устгал, ариутга     | 1,000,000.00          | 876,000.00     |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                  | 8,500,000.00          | 8,481,280.00   |
| 2105                  | <b>Нормативт зардал</b>                                      | 54,726,700.00         | 54,534,544.08  |
| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                              | 36,826,700.00         | 36,814,644.08  |
| 210502                | Хоол, хүнс   | 9,900,000.00          | 9,788,900.00   |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                  | 8,000,000.00          | 7,931,000.00   |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                     | 21,804,800.00         | 21,779,000.00  |
| 210601                | Багаж, техник, хэрэгсэл                                      | 14,840,500.00         | 14,820,000.00  |
| 210602                | Тавилга  | 6,000,000.00          | 6,000,000.00   |
| 210604                | Урсгал засвар  | 964,300.00            | 959,000.00     |
| 2107                  | <b>Томилолт, зочны зардал</b>                                | 1,700,000.00          | 728,000.00     |
| 210702                | Дотоод албан томилолт  | 1,700,000.00          | 728,000.00     |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хура</b> | 5,660,000.00          | 2,780,677.00   |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний        | 2,360,000.00          | 815,000.00     |
| 210803                | Даатгалын үйлчилгээ  | 300,000.00            | 54,450.00      |
| 210804                | Тээврийн хэрэгслийн татвар                                   | 150,000.00            | 72,000.00      |
| 210805                | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                | 150,000.00            | -              |
| 210807                | Газрын төлбөр  | 100,000.00            | 18,727.00      |
| 210808                | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж           | 1,000,000.00          | 231,000.00     |
| 210809                | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх                       | 1,600,000.00          | 1,589,500.00   |
| 2109                  | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                       | 1,159,500.00          | 1,150,000.00   |
| 210901                | Бараа үйлчилгээний бусад зардал                              | 1,159,500.00          | 1,150,000.00   |
| 213                   | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                      | 14,000,000.00         | 9,243,000.00   |
| 2132                  | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                | 14,000,000.00         | 9,243,000.00   |
| 213209                | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                      | 14,000,000.00         | 9,243,000.00   |
|                       | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                        | 663,695,200.00        | 642,344,402.32 |
| 1310                  | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                               | 617,489,500.00        | 617,489,500.00 |
| 131007                | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                     | 617,489,500.00        | 617,489,500.00 |
| 1320                  | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                        | 17,876,300.00         | 16,603,282.32  |
| 132001                | Орон нутгийн төсвөөс   | 17,876,300.00         | 16,603,282.32  |
| 1340                  | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>          | 28,329,400.00         | 8,251,620.00   |
| 134002                | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                    | 28,329,400.00         | 8,251,620.00   |
| 4                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл             | -                     | -              |
| 5                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл            | -                     | 7,512,000.18   |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх он | Гүйцэтгэл             |
|------------|--|----------|-----------------------|
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |          |                       |
| I          | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   |          | <b>218,540,156.91</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   |          | <b>218,540,156.91</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   |          | <b>177,940,156.91</b> |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил  |          | 46,731,621.37         |
| 210102     | Нэмэгдэл   |          | 35,019,919.37         |
| 210104     | Урамшуулал   |          | 11,711,702.00         |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл   |          | 5,838,882.22          |
| 210201     | Тэтгэврийн даатгал   |          | 5,838,882.22          |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  |          | <b>2,805,696.00</b>   |
| 210401     | Бичиг хэрэг  |          | 600,500.00            |
| 210402     | Тээвэр, шатахуун   |          | 1,269,696.00          |
| 210406     | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  |          | 935,500.00            |
| 2105       | <b>Нормативт зардал</b>  |          | <b>118,494,200.32</b> |
| 210501     | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл  |          | 77,694,200.32         |
| 210502     | Хоол, хүнс   |          | 10,640,000.00         |
| 210503     | Нормын хувцас, зөөлөн эдлэл  |          | 30,160,000.00         |
| 2106       | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   |          | <b>1,000,000.00</b>   |
| 210604     | Урсгал засвар  |          | 1,000,000.00          |
| 2107       | <b>Томилолт, зочны зардал</b>  |          | <b>1,214,757.00</b>   |
| 210702     | Дотоод албан томилолт  |          | 1,214,757.00          |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>  |          | <b>1,855,000.00</b>   |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил   |          | 1,855,000.00          |
| 213        | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  |          | <b>40,600,000.00</b>  |
| 2132       | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  |          | <b>40,600,000.00</b>  |
| 213209     | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  |          | 40,600,000.00         |
| II         | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | -        | <b>218,541,123.00</b> |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   |          | <b>218,541,123.00</b> |
| 131101     | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан  |          | 19,700.00             |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид жуваарилсан хөрөнгө |          | 42,100,503.00         |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны  |          | 5,300,000.00          |
| 131107     | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого  |          | 171,120,920.00        |
| IV         | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)</b>  |          |                       |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |          |                       |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  |          | 966.09                |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Уул сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулдаг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Уул сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 665.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 10.6 сая төгрөгөөр тооцсон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13.5 хувиар буюу 147.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 52.7 сая төгрөг болж 29.4 сая төгрөгөөр өссөн нь ковид 19 вирусын тархалтын үед хүлээн авсан эм, эмнэлгийн хэрэгсэл, түүний зарцуулалттай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 234.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 226.3 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, үйл ажиллагаандаа 431.4 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 52.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,502.7 сая төгрөг болж 29.6 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 20.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 31.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 82.4 сая төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна. Оны эцэст 1,502.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэлд Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос авах татаас санхүүжилтын 146.4 сая төгрөгийн авлага үүссэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,235.1 сая төгрөг болж 139.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл (35.6) сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 663.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс санхүүжүүлэхээр 617.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 17.9 сая төгрөг, ЭМД-ын сангаас 28.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 617.5 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 17.9 сая төгрөг, ЭМД-ын сангаас 8.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 634.8 сая төгрөгийг зарцуулж 1.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 634.8 сая төгрөг буюу 95.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 15.0 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 3.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2.9 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 4.7 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 218.5 сая төгрөгийн санхүүжилт орж, урсгал зардалд 218.5 сая төгрөгийг зарцуулж, тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 173 мэдээллээс 172 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 8.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар тээвэр шатахууны зарцуулалт, норм, бараа материалын тулгалтыг үзэх нь зүйтэй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 918.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.4 сая төгрөгийн алдаа залруулж, 916.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитын явцад тайлант хугацаанд шивүүлээгүй 1.4 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөж шивүүлсэн.

## 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй

## 4.3 Албан шаардлага

Жилийн эцсийн тооллогоор хөрөнгө тоолсон боловч 909.6 сая төгрөгийн хөрөнгийг дүгнэж тооллогын дүнг гаргаагүй, тооцоо бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Нийгмийн даатгалын тайлангаар 0.06 сая төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 6.9 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

## 4.4 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |       | Үүнээс    |     |               |     |                 |       |         |     |
|-----|-------------------------------------|----------------------|-------|-----------|-----|---------------|-----|-----------------|-------|---------|-----|
|     |                                     |                      |       | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |       | Зөвлөмж |     |
|     |                                     | Тоо                  | Дүн   | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн   | Тоо     | Дүн |
| 1   | Баян-Уул сумын Эрүүл мэндийн төв    | 3                    | 918.0 | 1         | 1.4 |               |     | 2               | 916.6 |         |     |